



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 606

Улаанбаатар хот

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэх аргачлал”-ын 3.6, 4.1, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмч эзэмшүүлэх гэрээний 2023 оны биелэлтээр төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, өмч хамгаалах Байнгын зөвлөлд өгөх зөвлөмжийг нэгдүгээр, Өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтээр “сайн” дүгнэгдсэн өмч эзэмшигч байгууллагын жагсаалтыг хоёрдугаар, хангалтгүй дүгнэгдсэн байгууллагын жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл), Захиргаа, удирдлагын хэлтэс (Н.Ганболд), Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа), Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Дэлгэрмаа)-т дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг тус тус даалгасугай:

2.1.Төрийн өмчийн 2023 оны өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийн дүнгээр хангалтгүй дүгнэгдсэн байгууллагуудын зөрчил дутагдлын талаарх мэдээллийг харьяалах дээд байгууллагад хүргүүлж, хариуцлага тооцох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2.Илэрсэн зөрчил дутагдлыг арилгах асуудлыг зохион байгуулах, хяналт шалгалт хийх, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад хандах (шилжүүлэх);

3.Төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт хавсралтад заасан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг даалгасугай;

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132602672
28-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 4 дугаар сарын 23-ны ний өдрийн
696 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны А/37 дугаар тушаал, түүний хавсралтаар баталсан удирдамжийн дагуу төрийн өмчит хуулийн этгээдүүдэд Төрийн өмч эзэмшүүлэх 2023 оны гэрээг дүгнэн баталгаажуулсан.

Төрийн өмч эзэмшүүлэх 2023 оны гэрээг дүгнэх явцад илэрсэн нийтлэг зөрчил дутагдлыг арилгахаар доорх үзүүлэлтэд заасан бичиг баримт материал бүрдүүлж ажиллана. Үүнд;

1. Хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдал.

1.1. Тооллогыг хийхдээ явцын тэмдэглэл хөтлөх, хөтөлсөн тэмдэглэл дээр эд хариуцагчаар гарын үсэг зуруулах, эзэмшил газрыг тогтоон тухайн газар дээр байрлах бүх хөрөнгийг тоолох, тооллогоор дутагдсан, бүртгэлгүй, ашиглалтын шаардлага хангахгүй, үлдэх өртөггүй, ашиглах хугацаа сунгах, актлах хөрөнгийн асуудлыг цаашид шийдвэрлэх санал, тооллогын хяналтын хуудас, тооллого хийсэн тухай тайланг бичих, нэгдсэн хөрөнгийн жагсаалтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 323 дугаар тогтоолын нэг болон хоёрдугаар хавсралтаар баталсан маягтаар хийх,

1.2. Өмч хамгаалах Байнгын зөвлөл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан төрийн өмчит хуулийн этгээдийн “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөн ажлаа хийх, төлөвлөгөө гарган ажиллах, Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хийсэн ажлын тайланг тусад нь архивлах,

1.3 Хөрөнгө хамгаалах, хадгалах асуудлыг анхаарах, тээврийн хэрэгсэл, барилгын хувийн хэрэг хөтлөх, өндөр өртөгтэй тоног тохөөрөмжийн паспортод баяжилт хийх, 2023 оны өмч эзэмшүүлэх гэрээний дүнгээр Төрийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем, Авто тээврийн үндэсний төв”-ийн улсын бүртгэл мэдээлэлтэй зөрүүтэй байгаа нь илэрсэн тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг тулган баталгаажуулж, зөрчил дутагдлыг 2025 оны 2 дугаар улиралд багтаан арилгах,

1.4 Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын дагуу гэрээ байгуулж түрээсэлэх, түрээсийн нийт орлогын 30 хувийг улсын төсөвт хугацаанд нь төвлөрүүлэх, улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын тооцоог жил бүрийн 12 сарын 5-ны дотор дуусгах.

2. Хөрөнгийн хөдөлгөөн, бүртгэл, мэдээ тайлан, шийдвэрийн хэрэгжилт, тайлагналтын байдал.

2.1. Бүртгэлгүй хөрөнгийг бүртгэлд хамруулах, илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийг шаардлагатай байгууллагад шилжүүлэх, ашиглуулах, дутагдсан хөрөнгийг нөхөн төлүүлэх, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагад хандах, маргаантай үндсэн хөрөнгийн асуудлыг тухай бүр шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад хандах; Хуулийн этгээдийн ерөнхий мэдээллийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын “open data”-тай мэдээлэлтэй зөрсөн, холбогдох өөрчлөлтийг хийлгээгүй, зөрчлийг арилгаж, байгууллагынхаа мэдээллийг шинэчлэх арга хэмжээг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан авч хэрэгжүүлэх;

2.2. Байгууллагын эзэмшлийн газар дээр байгаа нийтийн эзэмшлийн хөрөнгүүдийг тоолох, бүртгэлд авах,

2.3. Эд хөрөнгийн зохицуулалттай холбоотой тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хуулийн дагуу шийдвэрлэх, ялангуяа актлаж данснаас хасаж байгаа хөрөнгийн процесийг гүйцэт хийх, нотлох баримт бүрдүүлэх, аудитын зөвлөмж, акт, албан шаардлагыг биелүүлэх,

2.4. Үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, стандарт, бодлогын бичиг баримтын дагуу хөрөнгийн ашиглах хугацааг тогтоох, хөрөнгийг монгол хэлээр зөв оновчтой нэршлээр бүртгэх,

2.5. Тухайн жилд төрийн өмчийн эд хөрөнгийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, судалгаа, мэдээ тайлан гаргах ажлыг цаг хугацаанд нь тайлагнах,

3. Төрийн болон орон нутгийн өмчийн цахим мэдээллийн системийн байдал.

3.1. Төрийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын шилжилтийн суурь системд нэвтрэх эрх бүхий этгээд өөрчлөгдвөл актаар хүлээлцэх,


4. Газар эзэмших, ашиглах эрхийн байдал.

4.1. Газар эзэмших, ашиглах эрхийг цахимд систем (www.egazar.gov.mn)-д тогтмол шалгах, газрын талбайн хэмжээг анхаарч байх, тухайн зэрэглэлд хамаарах суурь үнэлгээ зөв эсэх, талбайн хэмжээг суурь үнэлгээгээр үржүүлэн нийт дүнг шалгах, бүртгэлд тусгах,

4.2. Газар эзэмших эрхийн хөдлөл өөрчлөлт (газрын хэмжээ, зориулалтад өөрчлөлт оруулах) гарсан тухай бүр асуудлыг шийдвэрлүүлэх, Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах, зөрчил, маргаан гарсан тохиолдолд хууль хяналтын байгууллагад хандах, асуудлыг шийдвэрлэсэн байх,

5. Гэрээний харилцааг зохицуулах журмын хэрэгжилт, бэлтгэл хангасан байдал.

5.1. Урд онуудын өмч эзэмшүүлэх гэрээний биелэлт, гэрээ (түрээс болон ашиглалтын гэрээ, хавсралт, сунгалтын хамт, ӨХБЗ-ийн ажлын тайлан, тооллогын баримт, барилга, тээврийн хэрэгслийн хувийн хэрэг, өндөр үнэтэй тоног төхөөрөмжийн техникийн паспорт, тээврийн хэрэгсэл болон өндөр үнэтэй тоног төхөөрөмж хариуцагч нартай байгуулсан “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ”, газар эзэмших эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, гэрээ гэх мэт)-ний бүрдлийг хангаж ажиллахыг зөвлөж байна.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 4 дугаар сарын 2-ны өдрийн
..... дугаар тогтоолын хоёрдугаар хаваралт

ТӨРИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ 2023 ОНЫ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭЭР
САЙН ДҮГНЭГДСЭН БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ


д/д	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Харьяалах дээд байгууллага	Гэрээний дугаар	Авбал зохих оноо	Оноо тоогоор	Оноо хувиар
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам									
1	Завхан	Улиастай сум	Завхан аймгийн Отгонтэнгэрийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа	9039554	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	2022/ЗА/02-0267	95	91	96%
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам									
2	Дорнод	Хэрлэн (Сүмбэр)	Дорнод аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	9032126	Барилга, хот байгуулалтын яам	2022/ДОА/03-0223	95	93	98%
3	Сүхбаатар	Баруун-Урт	Сүхбаатар аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	9053964	Барилга, хот байгуулалтын яам	2023/СУА/03-0353	95	92	97%
4	Сэлэнгэ	Сүхбаатар сум	Сэлэнгэ аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	9057528	Барилга, хот байгуулалтын яам	2023/СЭА/03-0331	95	91	96%
Боловсрол, шинжлэх ухааны яам									
5	Улаанбаатар	Налайх дүүрэг	Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль	5783224	Боловсрол, шинжлэх ухааны яам	2021/УБ/05-0450	100	96	96%
6	Дорноговь	Сайншанд сум	Дорноговь аймаг дахь мэргэжлийн боловсролын сургууль	9025812	Боловсрол, шинжлэх ухааны яам	2021/ДГА/20-0188	100	96	96%
7	Өвөрхангай	Арвайхээр	Өвөрхангай аймаг дахь Политехник коллеж	3559092	Боловсрол, шинжлэх ухааны яам	2024/ӨВА/20-1154	95	92	97%
Ерөнхийлөгчийн тамгийн газар									
8	Улаанбаатар	Сүхбаатар дүүрэг	Ерөнхийлөгчийн Тамгын газар	9128891	Ерөнхийлөгчийн тамгийн газар	2022/УБ/25-1245	85	82	96%

д/д	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Харъяалах дээд байгууллага	Гэрээний дугаар	Авбал зохих оноо	Оноо тоогоор	Оноо хувиар
Зам тээврийн яам									
9	Дорноговь	Сайншанд сум	Дорноговь АЗЗА ТӨХК	3306437	Зам тээврийн яам	2021/ДГА/14-0201	95	92	97%
10	Төв	Зуунмод сум	Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын Төв аймгийн Автотээврийн төв	5324165	Зам тээврийн яам	2023/ТӨА/08-0402	95	92	97%
11	Төв	Зуунмод сум	Төв АЗЗА ТӨХК	2053705	Зам тээврийн яам	2023/ТӨА/14-0406	100	96	96%
12	Хэнтий	Хэрлэн сум	Харгуй ТӨХК АЗЗА	2795671	Зам тээврийн яам	2023/ХЭА/14-1101	95	91	96%
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам									
13	Өвөрхангай	Арвайхээр	Өвөрхангай аймгийн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	5081092	Цахим хөгжил инновац, харилцаа холбооны яам	2024/ӨВА/14-1225	100	99	99%
14	Төв	Зуунмод сум	"Мэдээлэл холбоо сүлжээ" ХХК-ийн Төв аймаг дахь салбар	5081092	Цахим хөгжил инновац, харилцаа холбооны яам	2023/ТӨА/14-1233	100	96	96%
15	Улаанбаатар	Чингэлтэй дүүрэг	"Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХХК	5081092	Цахим хөгжил инновац, харилцаа холбооны яам	2021/УБ/14-1241	100	96	96%
Сангийн яам									
16	Баян-Өлгий	Өлгий сум	Гаалийн ерөнхий газрын харьяа Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газар	9003967	Сангийн яам	2022/БӨА/13-0042	95	92	97%
17	Сүхбаатар	Баруун-Урт	Сүхбаатар аймгийн Татварын газар	9051724	Сангийн яам	2023/СҮА/13-1501	95	92	97%
18	Хэнтий	Өндөрхаан	Хэнтий аймгийн татварын хэлтэс	9076492	Сангийн яам	2024/ХЭА/13-2101	95	91	96%
Улсын ерөнхий прокурорын газар									
19	Дорнод	Хэрлэн (Сүмбэр)	Дорнод аймгийн Прокурорын газар	9030786	Улсын ерөнхий прокурорын газар	2024/ДӨА/16-0222	95	93	98%
20	Баянхонгор	Баянхонгор сум	Баянхонгор аймгийн прокурорын газар	9007431	Улсын ерөнхий прокурорын газар	2024/БХА/16-0064	95	92	97%

д/д	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Харъяалах дээд байгууллага	Гэрээний дугаар	Авбал зохих оноо	Оноо тоогоор	Оноо хувиар
21	Улаанбаатар	Багануур дүүрэг	Нийслэлийн Багануур дүүргийн Прокурорын газар	9103465	Улсын ерөнхий прокурорын газар	2021/УБ/1 6-1065	95	91	96%
Улсын их хурал									
22	Улаанбаатар	Сүхбаатар дүүрэг	Авлигатай тэмцэх газар	5120829	Улсын их хурал	2017/УБ/1 7-0841	100	98	98%
23	Улаанбаатар	Цингэлтэй дүүрэг	Санхүүгийн зохицуулах хороо	5043239	Улсын их хурал	2021/УБ/1 7-0881	95	91	96%
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам									
24	Дорноговь	Замын-Үүд сум	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ	3308421	Уул уурхайн хүнд үйлдвэрийн яам	2021/ДГА/ 14-0202	95	93	98%
Үндэсний аудитын газар									
25	Дорнод	Хэрлэн (Сүмбэр)	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар	9030891	Үндэсний аудитын газар	2023/ДОА /20-0237	95	92	97%
26	Увс	Баруунтуруун сум	Увс аймаг дахь Төрийн аудитын газар	9065555	Үндэсний аудитын газар	2021/УВА/ 17-1273	85	82	96%
27	Хэнтий	Хэрлэн сум	Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар	9074082	Үндэсний аудитын газар	2024/ХЭА /17-1102	95	91	96%
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам									
28	Өвөрхангай	Арвайхээр	Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	9044035	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	2024/ӨВА /13-1155	95	93	98%
29	Дорнод	Хэрлэн (Сүмбэр)	Дорнод аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	9030972	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	2023/ДОА /23-001	95	91	96%
Хууль зүй, дотоод хэргийн яам									
30	Говь-Алтай	Есөнбулаг сум	Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	3245861	Хууль зүй, дотоод хэргийн яам	2024/ГАА/ 21-0112	85	82	96%
31	Дундговь	Сайнцагаан сум	Дундговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	9033874	Хууль зүй, дотоод хэргийн яам	2023/ДУА/ 26-0253	95	91	96%

д/д	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Хуулийн этгээдийн нэр	Регисрийн дугаар	Харъяалах дээд байгууллага	Гэрээний дугаар	Авбал зохих оноо	Оноо тоогоор	Оноо хувиар
32	Улаанбаатар	Баянгол дүүрэг	Цагдаагийн ерөнхий газрын Автобааз	9088148	Хууль зүй, дотоод хэргийн яам	2023/УБ/2 1-0726	100	96	96%
33	Улаанбаатар	Чингэлтэй дүүрэг	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	9080988	Хууль зүй, дотоод хэргийн яам	2023/УБ/2 6-0534	95	91	96%
34	Улаанбаатар	Баянгол дүүрэг	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги	9095993	Хууль зүй, дотоод хэргийн яам	2023/УБ/2 6-0876	95	91	96%
35	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг	Цагдаагийн ерөнхий газрын Хүч спорт хороо	9095616	Хууль зүй, дотоод хэргийн яам	2023/УБ/2 1-0778	95	91	96%
36	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг	Дотоод хэргийн их сургууль	1701282	Хууль зүй, дотоод хэргийн яам	2023/УБ/2 1-0932	100	96	96%
Шадар сайд									
37	Баян-Өлгий	Өлгий сум	Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газар	9005889	Шадар сайд	2021/БӨА/ /24-0027	95	91	96%
38	Дархан-Уул	Дархан	Дархан-Уул аймгийн стандарт, хэмжил зүйн хэлтэс	9023178	Шадар сайд	2023/ДАА/ 24-0173	100	96	96%
39	Дорнод	Баяндун сум	Дорнод аймгийн стандарт хэмжил зүйн хэлтэс	9030794	Шадар сайд	2023/ДОА/ /24-0233	100	96	96%
Шүүхийн ерөнхий зөвлөл									
40	Говьсүмбэр	Сүмбэр сум	Говьсүмбэр аймаг дахь шүүхийн тамгын газар	9018468	Шүүхийн ерөнхий зөвлөл	2021/ГСА/ 25-0135	95	92	97%
41	Увс	Улаангом сум	Увс аймаг дахь шүүхийн тамгын газар	9065008	Шүүхийн ерөнхий зөвлөл	2021/УВА/ 25-0417	95	92	97%
42	Улаанбаатар	Налайх дүүрэг	Багахангай, Налайх дүүргийн Шүүхийн тамгын газар	5792738	Шүүхийн ерөнхий зөвлөл	2021/УБ/2 5-1001	95	92	97%
43	Дорноговь	Замын-Үүд сум	Дорноговь аймгийн Замын-үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	9028196	Шүүхийн ерөнхий зөвлөл	2021/ДГА/ 25-0190	95	91	96%

д/д	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Харьяалах дээд байгууллага	Гэрээний дугаар	Авбал зохих оноо	Оноо тоогоор	Оноо хувиар
44	Ховд	Жаргалант сум	Ховд аймаг дахь шүүхийн тамгын газар	9066403	Шүүхийн ерөнхий зөвлөл	2021/ХОА/25-1092	95	91	96%
45	Баянхонгор	Баянхонгор сум	Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газар	9007458	Шүүхийн ерөнхий зөвлөл	2024/БХА/25-0062	95	91	96%
Эрчим хүчний яам									
46	Дорнод	Хэрлэн (Сүмбэр)	Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК	2628651	Эрчим хүчний яам	2023/ДОА/14-0231	100	98	98%
47	Дархан-Уул	Дархан	Дархан-Уул аймгийн "Дулааны цахилгаан станц" ТӨХК	2688549	Эрчим хүчний яам	2022/ДАА/14-0160	100	97	97%
48	Ховд	Жаргалант сум	Ховд Цахилгаан түгээх сүлжээ ХХК	2684853	Эрчим хүчний яам	2022/ХОА/14-1331	100	97	97%
49	Завхан	Улиастай сум	"Алтай Улиастай эрчим хүчний систем" ТӨХК-ийн Завхан салбар	3490777	Эрчим хүчний яам	2022/ЗА/14-1279	95	92	97%
50	Дархан-Уул	Дархан	Дархан-Уул аймаг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ салбар	2685221	Эрчим хүчний яам	2023/УБ/222	100	96	96%



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 5 дугаар сарын 25-ны/ний өдрийн
60х дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ 2023 ОНЫ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭЭР
ХАНГАЛТГҮЙ ДҮГНЭГДСЭН БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

д/д	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Харъяалах дээд байгууллага	Гэрээний дугаар	Авбал зохих оноо	Оноо тоогоор	Оноо хувиар
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам									
1	Улаанбаатар	Чингэлтэй дүүрэг	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	9085084	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	2022/УБ/02-0943	95	43	45%
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам									
2	Улаанбаатар	Чингэлтэй дүүрэг	Барилга, хот байгуулалтын яам	9129308	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	2021/УБ/03-0821	95	30	32%
3	Дорноговь	Сайншанд сум	Дорноговь аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	9029141	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	2021/ДГА/03-0184	95	61	64%
4	Булган	Булган сум	Булган аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	3185761	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	2022/БУА/03-0091	95	62	65%
Боловсрол, шинжлэх ухааны яам									
5	Сэлэнгэ	Сүхбаатар сум	ХААИС-ын харьяа Сэлэнгэ аймаг дахь политехник коллеж	9055517	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	2023/СЭА/20-0335	95	42	44%
6	Улаанбаатар	Сүхбаатар дүүрэг	Монгол Улсын Их Сургууль	9104399	Боловсрол, шинжлэх ухааны яам	2021/УБ/05-1012	100	43	43%

д/д	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Хуулийн этгээдийн нэр	Регисрийн дугаар	Харъяалах дээд байгууллага	Гэрээний дугаар	Авбал зохих оноо	Оноо тоогоор	Оноо хувиар
7	Говьсүмбэр	Сүмбэр сум	Говьсүмбэр аймаг дахь политехник коллеж	4611853	Боловсрол, шинжлэх ухааны яам	2021/ГСА/20-1515	100	58	58%
Зам тээврийн яам									
8	Булган	Булган сум	Булган АЗЗА ТӨХК	2882191	Зам тээврийн яам	2021/БУА/14-0101	95	30	32%
9	Завхан	Тосонцэнгэл сум	Завхан АЗЗА ТӨХК	2103699	Зам тээврийн яам	2017/ЗА/14-1223	95	71	75%
Сангийн яам									
10	Завхан	Алдархаан сум	Завхан аймгийн татварын хэлтэс	9039023	Сангийн яам	2021/ЗА/13-1101	95	59	62%
11	Өмнөговь	Даланзадгад сум	Өмнөговь аймгийн Татварын хэлтэс	9047816	Сангийн яам	2021/ӨМА/13-1401	95	67	71%
Улсын ерөнхий прокурорын газар									
12	Улаанбаатар	Сүхбаатар дүүрэг	Нийслэлийн прокурорын газар	1701177	Улсын ерөнхий прокурорын газар	2022/УБ/16-0721	95	65	68%
Үндэсний аудитын газар									
13	Баян-Өлгий	Өлгий сум	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар	9007245	Үндэсний аудитын газар	2022/БӨА/17-0037	85	45	53%
Хууль зүй, дотоод хэргийн яам									
14	Архангай	Эрдэнэбулган	Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	9001433	Хууль зүй, дотоод хэргийн яам	2022/АРА/ 26-0014	95	62	65%
15	Архангай	Эрдэнэбулган	Архангай аймаг дахь Шүүх шинжилгээний хэлтэс	3002292	Хууль зүй, дотоод хэргийн яам	2024/АРА/21	95	66	69%
16	Завхан	Улиастай сум	Завхан аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	9039929	Хууль зүй, дотоод хэргийн яам	2021/ЗА/26-0261	95	70	74%
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам									

д/д	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Харьяалах дээд байгууллага	Гэрээний дугаар	Авбал зохих оноо	Оноо тоогоор	Оноо хувиар
17	Улаанбаатар	Хан-Уул дүүрэг	Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК	6829147	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2024/УБ/23-0441	95	41	43%
18	Архангай	Эрдэнэбулган	Архангай аймгийн Мал эмнэлгийн газар	3011615	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2022/АРА/23-1400	95	49	52%
19	Улаанбаатар	Хан-Уул дүүрэг	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв	6626696	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2024/УБ/СХТ/001	100	63	63%
20	Сүхбаатар	Баруун-Урт	Сүхбаатар аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар	9054146	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2024/СҮА\16-1432	95	49	52%